

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№ 07/280

НШУС

2007

**"МОНГОЛЫН УВАШИ ХҮН ТАЙЖИЙН ТУУЖ" ДАХЬ  
"ЗАНГИ" ГЭДЭГ ҮГИЙН ТУХАЙ**

Бүрээчин Дархан\*

\* ӨМӨЗО-ны Хөх хотын их сургуулийн профессор

Хөрвүүлсэн: Л.Норовсүрэн

**Түлхүүр үг:** Ойрад монгол, тууж, занги.

**A**гуулгын товч. Тус өгүүлэлд зохиогчоос "Монголын Увashi Хун тайжийн тууж"-д "Занги" гэдэг үг 11 байгааг тоолон гаргаж "Занги" гэдэг үг бол XYI зууны үед Ойрад нутагт өргөн хэрэглэгдэж байсан үндсэн үг гэж үзсэн байна. "Занги" гэдэг үг бол Ойрад нутгийн аялгууны үг болох ба тэр нь эдүүгээгийн "мэдээ занги" гэдэг нэр томъёо буй болоход чухал үйлдэл үзүүлэв гэж үзжээ.

"Монголын Увashi Хун тайжийн тууж" бол Ойрад уран зохиол юм. Тус тууж Ойрад нутгийн аялгуугаар зохиогдож, тод үсгийн гар бичмэлээр уламжлагдан тархаж байжээ. 1858 онд тус туужийг буриад лам Гомбын Галсан Петербург хотод анх удаагаа тод үсгээр хэвлүүлжээ. 1959 онд Монгол улсын эрдэмтэн

Ц.Дамдинсүрэн "Зуун билэг" хэмээх монгол уран зохиолын томоохон дээж бичиг хэвлүүлэхдээ тус туужийг нэг дээж болгон сонгож уйгаржин монгол үсгээр хэвлүүлсэн байна.

Ц.Дамдинсүрэн тус туужид хэвлэн нийтлэгчийн тодорхойлол хадаадаа "Увashi Хун тайжийн туужийг Дрездинд байгаа мөн туужийн фото зургийг гол болгож буриад лам Гомбын Галсангийн хэвлүүлсэн тод үсгийн эх ба Монгол улсын номын санд байгаа уйгаржин монгол үсгийн эхтэй нийлүүлэн засаж хэвлэв" гэж бичсэн ба туужийн гол хэсгийн өдий төдий газарт үг, үсгийн товчоо, тайлбар хийсэн байна. "Зан" буюу "занги" гэдэг үг тус дугаарт нийт арванхоёр удаа гарна. Үүний дөрвөн үгэнд нь Ц.Дамдинсүрэн "мэдээ" гэсэн тайлбар хийжээ. Тус дугаарт гарч бүхий арванхоёр "зан"-гийн арван нэг нь нээрэн "мэдээ" гэдэг утгатай. Зөвхөн

нэгээхэн уг л "зан араншин" гэдэг утгатай байна. Доор "Монголын Уваши хунтайжийн тууж" дэх "зан" буюу "занги" гэдэг арванхоёр үгийг дэс дараалан тоолон үзүүлбэл ийм байна.

1. Хамаг эхний улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Дөрвөн ойрадын зан нь нутагтаа ирсэн дайсанд холч морь, хоточ нохой мэт тарамдаж үл олддог биш үү" гэсний "зан" гэдэг нь "зан араншин" гэдэг үг юм.

2. Дөрөвдүгээр улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Оловч эс оловч найман хоногт чанагш явж, нааш ирж зангиан өгдөг" гэсний "зангиан" гэдэг нь "мэдээгээ" гэдэг утгатай.

3. Тавдугаар улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Хоёр зуун туршуул дундаа авч суулгаад занги нь сурав" гэсний "занги нь" гэдэг нь "мэдээг нь" гэдэг утгатай.

4. Есдүгээр улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Дөрвөн ойрадын "занг мэдэхүл" гэсний "занги нь" гэдэг нь "мэдээ нь" гэдэг утгатай.

5. Мөнхүү есдүгээр улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "занги нь энэ" гэсний "занги нь" гэдэг нь "мэдээ нь" гэдэг утгатай.

6. Арванзургадугаар улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Ойрадын хөвгүүн дөрвөн зүтг буй, миний занги энэ" гэсний "занги" гэдэг нь "мэдээ" гэдэг утгатай.

7. Арванесдүгээр улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Ойрадын зангийг

мэдүүлнэ би" гэсний "Зангийг" гэдэг нь "мэдээг" гэсэн утгатай.

8. Хоринтавдугаар улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Харь Дөрвөн ойрадын занги тэр биш үү" гэсний "занги" гэдэг нь "мэдээ" гэдэг утгатай.

**9.** Хоринтавдугаар улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Тэгээд баахан боловсон иргэд Дөрвөн ойрадын занги нь Уваши хун тайжид мэдээлжээ" гэсний "занги нь" гэдэг нь "мэдээг нь" гэдэг утгатай.

10. Мөнхүү хоринтавдугаар улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Ойрадын занги энэ" гэсний "занги" гэдэг нь "мэдээ" гэдэг утгатай.

11. Хориндолдугаар улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Хэл барьж Дөрвөн ойрадад занги оруул" гэсний "занги" гэдэг нь "мэдээ" гэдэг утгатай.

12. Хоринесдүгээр улаан мөрөөр эхэлсэн бадаг дахь "Орог саарлыг минь талбигтун, нутагт занги оруултугай" гэсний "занги" гэдэг нь "мэдээ" гэдэг утгатай.

"Монголын Уваши Хунтайжийн тууж" бол дайнаар сэдэв материал болгосон баримтат уран зохиол юм. Тус туужид XYI зууны сүүлч буюу XYII зууны эхний үед Зүүн Монгол, Баруун Монголын хоорондох дотоодын дайны түүхт хэргийг тэмдэглэн тусгасан байна. Туужид гарах Лайхур хан, Уваши Хунтайж, Байбагас хан нар бол бүр Зүүн Монгол, Баруун Монгол харилцан тулалдаж

байсан үеийн түүхт хүмсүүд болно. Туужийн үлгэр үйл явдал нь будлиантай биш, хоёр этгээдийн дайн нь Зүүн Монголын Уваши хунтайж хийгээд Баруун Монголын Байбагас ханы хооронд руун Монголын Байбагас ханы ялагдал, болдог бөгөөд дайны үр дүн нь Зүүн монголын Уваши хунтайжийн ялагдал, Баруун монголын Байбагас хааны ялалтаар дусдаг байна.

Зүүн Монголын Уваши хунтайж бол шударга бус дайныг

өдөөж ялагдалд учирсан ба Баруун монголын Байбагас хаан бол төрсөн нутаг, тайван амьдралаа хамгаалахын төлөө шударга дайныг хийсэн тул ялалт олжээ. Туу-

жийн төгсгөлд энэ дайныг "гал гахай жил" (1587 он)-д болов гэж тэмдэглэж байна. Дайны үйл явдлыг бичсэн зохиол нь дайн байлдаан лугаа холбогдолтой нууц мэдээнүүдийг чухалчлах нь мэдээжийн хэрэг юм. Тийнхүү тус туужид "мэдээ" гэдэг үг арваннэгэн удаа давтагдан гарсан байна. Энд давтагдан гарч буй "мэдээ" нь дайны орчин тойронд бол "нууц мэдээ" (Чин бао) – нүүд болно. Гэтэл энх тайван үед бол "мэдээ чимээ" (Шинь ши) – нүүд болно. "Зан" буюу "Занги" гэдэг үг бол XYI зууны үед ойрад нутагт өргөн хэрэглэгдэж байсан үндсэн

үг болох ажээ. "Занги" гэдэг үг XYIII зууны үед толь бичигт элсэгджээ. 1717 онд модон бараар хэвлэгдсэн Монгол чуудын тайлбар толь болох "Хорин нэгт тайлбар толь"-д "зан ги" хэмээн бичиж буй бөгөөд үгийн утгыг "мэдээ хэмээх үг" гэж тайлбарласан байна. "Хорин нэгт тайлбар толь"-д "мэдээ" гэдэг үгийг "Аливаа сонссон хэргийг мэдээ хэмээ мой" гэж тайлбарлажээ. "Хорин нэгт тайлбар толь"-д бичигдэн бүхий "занги" буюу "мэдээ" нь бүр одоогийн Монгол хэлэн дэх "мэдээ чимээ" буюу "мэдээ занги" гэсэн утгаар илэрч байна.

XX зууны ертөнцөд мэдээ зангийн хувьсгал өрнөж, манайхан мэдээ зангийн хамаатай нэр томъёо бүтээх үед толь бичигт тэмдэглэгдсэн "занги" гэдэг үгээ авч гаргажээ. Тийнхүү "занги" гэдэг үгэнд суурилсан "мэдээ занги", "сураг занги", "чимээ занги" гэх мэтийн үгнүүд буй болсон юм.

«

»

үед толь бичигт тэмдэглэгдсэн "занги" гэдэг үгээ авч гаргажээ. Тийнхүү "занги" гэдэг үгэнд суурилсан "мэдээ занги", "сураг занги", "чимээ занги" гэх мэтийн үгнүүд буй болсон юм. Тэгээд Ойрад нутагт эртдээ өргөн хэрэглэгдэж байсан үг "занги" нь нэг мэдэхэд бүх дундад улсын нутаг дэвсгэр дээр байр эзлэх болжээ. "Монгол-Хятад толь"-д "занги" гэдэг үгийг "мэдээ занги" (Шао Ши) гэж тайлбарласан. "Хятад-Монгол толь"-д "сураг занги" (Шинь Ши) гэдэг үгийг "сураг", "мэдээ", "сураг чимээ" гэж

тайлбарласан байна. "Занги" гэдэг уг нэлээд эрт толь бичигт элсэгдсэн боловч даяар монголд дэлгэрч чадсангүй юм. Дэлгэрэл гэвэл одоо л сая эхлэн дэлгэрч байна. "Занги" бол "мэдээ"-тэй адилаар тул их амьдрах хүчинтэй уг болох ажээ. Түүний үгийн сангийн утгыг бид толь бичиг буюу сурвалж бичгээс хариулт олж байна. Гэтэл түүний язгуур гарлыг одоод мөн хараахан олж мэдээгүй байна.

"Занги" гэдэг уг нь жинхэнэ ойрад гаралтай уг юм уу? эсвэл харь гаралтай уг юм уу? гэдгийг улам нэг алхам тодлууштай байна.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Ц. Дамдинсүрэн. 1959. Монгол уран зохиолын дээж зуун билэг оршвой. УБ. 188 дахь тал.
2. 1977. Хорин нэгт тайлбар толь. Хөх хот. 790, 493 дахь тал.
3. 1976. Монгол-Хятад толь. Хөх хот. 1275 дахь тал.
4. Хятад-Монгол толь. Хөх хот. 1983. 1791 дэх тал.